ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 02 сарын 17 өдөр Дугаар 03/03 Арвайхээр сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.13, Боловсролын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Багш нарын хөгжил, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлж, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжид ахиц гаргах зорилготой “Багшийн хөгжил” аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга О.Пүрэвдоржид даалгасугай.

ДАРГА Т.НАРАНГАРАВ

D:/ИТХ/nuuts2025/1.togtool/togtool.doc

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн
04/102 дугаар тогтоолын хавсралт

“БАГШИЙН ХӨГЖИЛ”

Аймгийн хөтөлбөр
(2025-2028 он)

НЭГ. УДИРТГАЛ

1.1 Нийтлэг үндэслэл

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн нэг чухал хэмжээс нь хүний хөгжил бөгөөд энэ нь улс орны засаглал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн цөм, хөдөлгөгч хүч нь болдог. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж, энэхүү бодлогын 2.1-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” хэмээн хүн төвтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Мөн 2021-2030 онд хэрэгжүүлэх Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөнд “Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан, мэдлэгт суурилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх, дижитал технологийн эринд ажиллаж амьдрах, нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай, эрүүл иргэнийг цогцоор хөгжүүлэх”-ээр заажээ.

Дээрх бодлого, зорилтын хүрээнд боловсролын хөгжлийн олон улсын чиг хандлага, хувьсан өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнцөд шинээр бий болж буй өргөн боломж, түүний дотор технологийн дэвшлийг ашиглан мэдлэг, боловсрол эзэмших арга хэлбэр зэргийг уян хатан, тэгш, хүртээмжтэй хөгжүүлэх, бүх шатны боловсролын багш, удирдах ажилтныг чадавхжуулах, хүний нөөцийг тогтвортой бүрдүүлэх зэргээр хүүхэд нэг бүрд хүрэх сургалтын чанар, үр нөлөөг сайжруулах бодит хэрэгцээ, шаардлага нэмэгдсээр байна.

2024-2025 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд боловсролын сургалтын 80 байгууллагад нийт 3526 албан хаагч, үүнээс 2212 багш, удирдах ажилтан ажиллаж байна. Нийт багш нарын 56.2 хувь мэргэшлийн зэрэгтэй, үүнээс зөвлөх 19, тэргүүлэх 437, заах аргач зэрэгтэй 534, боловсролын зэргийн хувьд 70.2 хувь нь бакалавр, 16.8 хувь нь магистр зэрэгтэй багш удирдах ажилтан байна.

Боловсролын салбарт 2022 оноос эхлэн “Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт” төсвийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлж буй багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 2024 оны байдлаар 5 дугаар түвшин буюу хангалтгүй үнэлэгдсэн 488 багш байгаа нь нийт багш нарын 38 хувийг эзэлж, тус үнэлгээний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт сургуулийн өмнөх боловсролд 75 хувь, ерөнхий боловсролын сургуульд 60.6 хувь байна.

Манай аймгийн хувьд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хүртээмж, сургалтын чанар, үр дүн, багшийн заах, арга ур чадварын түвшингээр улсад тэргүүлэх амжилтад хүрэхэд цөөнгүй бодлого, шийдвэр, хөтөлбөр, арга

хэмжээг баталж хэрэгжүүлсэн боловч тэдгээрийг нэгдсэн үзэл баримтлалын хүрээнд боловсруулж, хэрэгжилтийг тогтвортой хангах санхүү, төсөв болон багшийн тасралтгүй хөгжих хэрэгцээнд тулгуурласан орчин, нөхцөл хангалтгүй байсан нь сорилт, бэрхшээл болж ирсэн. Тухайлбал багш нарын ээлжит хичээлийн явцад хийсэн ажиглалт судалгаагаар 90 гаруй хувь нь уламжлалт "багш төвтэй" буюу мэдлэгийг шууд дамжуулах арга барилыг хичээл сургалтдаа ашигласаар байгаа нь 21 дүгээр зууны суралцахуй болон багшлахуйн зарчимд нийцэхгүй байна. Мөн 2024-2025 оны хичээлийн жилд 15 судлагдахууны 50 багшийн үндсэн, 19 түр орон тоонд багш дутагдалтайн зэрэгцээ 28 тэтгэврээ тогтоолгосон ахмад багш ажиллаж байгаа нь хүний нөөцийн бүтээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэртэй бус байдал бий болоход нөлөөлж байна.

Иймд бүх шатны боловсролын байгууллагын хөдөлгөгч хүч болсон багшийн ажлын байрны тасралтгүй хөгжлийг дэмжих, тэдэнд тогтвор суурьшилтай ажиллах боломж, нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч, орон нутгийн нэгдсэн бодлогыг төлөвлөн, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

1.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

1.2.1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030), Боловсролын ерөнхий хууль, түүний дагалдах хуулиуд, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон аймаг орон нутгийн бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байх

1.2.2. Хөтөлбөр нь багш, удирдах ажилтан бүрийн нийгмийн хариуцлага, хөгжлийн түвшин, эрэлт хэрэгцээ, сонирхол, боломж нөхцөлд тулгуурлах

1.2.3. Хөтөлбөрт тусгагдсан багшийн хөгжил оролцоо, нийгмийн баталгааг дэмжих үйл ажиллагаа нь орон нутгийн онцлогтой уялдсан, нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх

1.2.4. Хөтөлбөрийн үйл ажиллагааг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

1.2.5. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын төсөл хөтөлбөр, иргэдийн санаачилга зэрэг бүх талын дэмжлэг, оролцоог хангах.

1.3 Хөтөлбөрийн зорилго, зорилт

1.3.1 Хөтөлбөрийн зорилго

Багш нарын тасралтгүй хөгжил, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлж, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжид ахиц гаргахад оршино.

1.3.2 Хөтөлбөрийн зорилт

1.3.2.1. Багш, удирдах ажилтны тасралтгүй хөгжлийг хангах, хамтын оролцоог нэмэгдүүлэх замаар чадварлаг багшийг бэлтгэх, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх

1.3.2.2. Багшийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн, мэргэжлийн багшаар бүрэн хангах

1.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, хамрах хүрээ

1.4.1 Хөтөлбөрийг 2025-2028 он хүртэл 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

1.4.2 Өвөрхангай аймгийн төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, насан туршийн боловсролын багш, багшийн туслах, удирдах ажилтан болон Боловсролын газрын арга зүйч/мэргэжилтнүүдийн хүрээнд үйлчилнэ.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилт 1. Багш, удирдах ажилтны тасралтгүй хөгжлийг хангах, хамтын оролцоог нэмэгдүүлэх замаар чадварлаг багшийг бэлтгэх, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх хүрээнд:

2.1.1. Багшийн хөгжлийн цогц төв “Багш хөгжлийн ордон”-ыг шинээр байгуулах

2.1.2. Ерөнхий боловсролын сургууль бүрд “Багшийн хөгжлийн төв”-ийг үе шаттай байгуулах;

2.1.3. Мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагаагаар багш нарын хамтран ажиллах чадавхыг нэмэгдүүлж, сургагч болон чиглүүлэгч /ментор/ багшийг бэлтгэн, сайн туршлага, арга зүйг сургалт, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

2.1.4. Сургалтын заах арга зүйн мэдлэг, ур чадварыг шинэ түвшинд хүргэхэд чиглэсэн /танхимын болон цахим/ сургалт, семинар зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулах;

2.1.5. Залуу багш нарыг дагалдуулан суралцуулах, чадварлаг залуу багшийг төлөвшүүлэх, ахмад болон зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй багш нарын сайн туршлага арга зүйг түгээн дэлгэрүүлэх, багш солилцоо арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.1.6. Сургалт, үйл ажиллагаагаар тэргүүлэгч шилдэг менежменттэй ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдээс туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах

2.1.7. Багш, удирдах ажилтны гадаад улсад мэргэжил дээшлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран ажиллах;

2.1.8. Боловсролын болон мэргэшлийн тэргүүлэх, зөвлөх зэрэгтэй багш, удирдах ажилтан, судлаач багшийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

2.1.9. Сургалтын байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын зөвлөн туслах багийг ажиллуулж, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.1.10. Олон улсын байгууллагын болон сайн дурын багш, ажилтнуудтай хамтран ажиллах;

Зорилт-2 Багшийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн, мэргэжлийн багшаар бүрэн хангах хүрээнд:

2.2.1. Багш, удирдах ажилтны ёс зүй, хандлага, манлайллыг сайжруулах, нэр хүнд үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн онөвчтой үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэх

2.2.2. Багш, удирдах ажилтан хуулиар хүлээсэн ажил үүргээ гүйцэтгэх явцад аливаа хэлбэрээр хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх, хүйсээр ялгаварлан гадуурхах зэргээр нэр хүндэд нь халдсан тохиолдолд багш, удирдах ажилтныг хамгаалах

2.2.3. Хөдөө орон нутагт багшлах боловсон хүчний тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлж, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, орон сууцны урьдчилгааны тодорхой хувийн хөнгөлөлт үзүүлэх, гэр бүлийн хэрэгцээний газар өмчлүүлэх/эзэмшүүлэх, зэрэг боломжуудыг судлан хэрэгжүүлэх

2.2.4. Чадварлаг багш, удирдах ажилтны болон мэргэжлийн хөгжлийн бүлгийн ур чадвар, манлайллыг хөхүүлэн дэмжих, шагнал урамшууллын журам шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;

2.2.5. Хичээлээс гадуурх секц, дугуйлан, клуб, хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагын үйл ажиллагааны чанар, ур дүнг харгалзан чиглүүлэгч багшид нэмэлт урамшуулал олгох

2.2.6. Багш, удирдах ажилтнуудыг компьютер, шаардлагатай техник хэрэгслээр үе шаттай хангах

2.2.7. “Багш сонгон бүлэг”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хамрагдах суралцагчдын тоог нэмэгдүүлэх, нэн шаардлагатай мэргэжлийн багшийг бэлтгэх, мэргэшүүлэх, хөрвүүлэн сургах чиглэлээр багш бэлтгэдэг их, дээд сургуультай хамтран ажиллах;

2.2.8. Багш, удирдах ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог ур дүнтэй зохион байгуулах, эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулах, рашаан сувилалд амрах, эмчлүүлэхэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх

2.2.9. Багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэж мэргэжлийн багшаар бүрэн хангах чиглэлээр санаачилгатай ажилласан сум, орон нутгийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, алдаршуулах арга хэмжээг зохион байгуулах;

2.2.10. Багш мэргэжлийн үнэ цэн, үйл ажиллагаа, ур чадвар, ололт амжилтыг сурталчлах, хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

2.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

2.2.1. Орон нутгийн түвшинд багшийн хөгжлийг дэмжих бодлого тодорхой болж, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, ажлын байрандаа тасралтгүй хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлснээр багшлахуй болон удирдахуйн мэдлэг, ур чадвар, ээлжит хичээлийн чанарт ахиц гарч, сургалтын чанарын аймгийн дундаж үзүүлэлт 54.5 хувьтай байгааг 60 хувьд хүргэнэ.

2.2.2. Багш, удирдах ажилтнуудын багаар ажиллах арга барилд ахиц гарч, харилцан суралцах боломжийг бүрдүүлснээр сургалтын байгууллага дээрх мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг тогтмолжуулж, бүлгийн тоо 98 байгааг 2 дахин нэмэгдүүлнэ.

2.2.3. Боловсрол, сургалтын байгууллагын багш, удирдах ажилтнуудын мэргэжил арга зүй, хамтын ажиллагаа дээшилснээр суралцагчдын хөгжил хамгааллын үйл ажиллагаа сайжирна.

2.2.4. Мэргэжлийн багш, хүний нөөцийг бүрдүүлэх олон талт үйл ажиллагааг төр, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, багшийн хангалтыг 100 хувьд хүргэнэ.

2.3. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин				Төсөв, эх үүсвэр (сая төгрөг)
			2025	2026	2027	2028	4 жилдээ
1.Багш, удирдах ажилтны тасралтгүй хөгжлийг хангах, хамтын оролцоог нэмэгдүүлэх замаар чадварлаг багшийг бэлтгэх, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх	Ерөнхий боловсролын сургуулийн "Багш хөгжлийн төв"-ийн тоо	4	10	10	10	-	600,0 (Улсын төсөв)
	Гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах арга хэмжээнд хамрагдсан багш, ажилтны тоо	21	100	100	100	100	1,200,0 (Орон нутаг)
	Багш нарын мэргэжлийн онолын мэдлэгийн ахицын хувь	41.7	45.0	50.0	55.0	60.0	-
	Сургалтын чанарын аймгийн дундаж үзүүлэлт	54,5	55,5	57,0	59,0	60,0	-
	Багш солилцоо арга хэмжээнд хамрагдсан багш, албан хаагчийн тоо	80	100	100	100	100	-
	Мэргэшлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь	56,2	58,0	60,0	62,0	65,0	-
	Магистрын зэрэг хамгаалсан багшийн тоо	348	10	10	10	10	-
	Суралцахуйд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлэг	70	90	110	130	150	-
	Судлагдахуунд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлэг	30	40	50	60	70	-
	Багш нарын дунд зохион байгуулсан эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлын тоо	1	1	1	1	1	10,0 (Орон нутаг)
	Сургууль, цэцэрлэгүүдэд зохион байгуулсан зөвлөх үйлчилгээний тоо	10	20	20	20	20	-

2.Багшийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн, мэргэжлийн багшаар бүрэн хангах	Тэтгэлэг, хөнгөлөлтөд (орон сууцны хөнгөлөлт, гэр бүлийн хэрэгцээний газар, сургалтын төлбөр бусад) хамрагдсан багшийн тоо	5	10	20	20	20	600,0 (Орон нутаг)
	Шагнал, урамшуулалд хамрагдсан багшийн тоо (журмын хүрээнд)	20	30	30	30	30	320,0 (Орон нутаг)
	Секц, дугуйлан, клубийг хичээллүүлж, хүүхдийн өөрөө удирдах байгууллагыг үр дүнтэй чиглүүлж, нэмэлт урамшуулал авсан багшийн тоо	-	20	20	20	20	-
	Мэргэжлийн багшийн хангалтын хувь	96,2	97,0	98,0	99,0	100,0	-
	Сургалтын байгууллагын менежмент, албан хаагчдын ёс зүй, манлайллын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн хувь	80	100	100	100	100	-
	Багш сонгон бүлэгт элсэн суралцаж буй хүүхдийн тоо	19	20	20	20	20	10,0 (Орон нутаг)
	Багш нарын үйл ажиллагааг дэмжиж, урамшуулсан сумын тоо	9	19	19	19	19	
	Эмчлэн эрүүлжүүлэх эрүүл мэндийн хөнгөлөлт дэмжлэгт хамрагдсан багшийн тоо	180	250	350	400	500	-
НИЙТ ТӨСӨВ							**2,740,0**

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТ, САНХҮҮЖИЛТ

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

3.1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, хамтын ажиллагаагаар уялдуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсролын газар хариуцна.
3.1.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх асуудлыг хариуцна.
3.1.3. Сумын Засаг дарга нар тухайн орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг боловсруулан, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
3.1.4. Хөтөлбөрийг төрийн байгууллагын төсөв, өөрийн орлого (аймаг, орон нутгийн төсөвт хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр тухайн байгууллагын төсвийн 0,5-1,0 хүртэл хувийг төлөвлөх)

3.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

3.2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг сумын Засаг дарга нар гүйцэтгэж үр дүн, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.
3.2.2. Боловсролын газар нь жил бүр холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээг хийлгэх бөгөөд хөтөлбөрийн тайланг тухайн оны 12 дугаар сард багтаан, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулна.
3.2.3. Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсролын газар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.
3.2.4.Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

3.3. Хөтөлбөрийн санхүүжилт

3.3.1. Улсын болон орон нутгийн төсөв
3.3.2. Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн санхүүжилт
3.3.3. Аж ахуйн нэгж, иргэдийн хандив тусламжийн санхүүжилт
3.3.4. Бусад эх үүсвэрийн санхүүжилт.

-----oOo-----